



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16-дээр

Дугаар 224

Улаанбаатар хот

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв”  
төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын  
бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг  
өөрчлөн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн схемийг 1 дүгээр, албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.

2.“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 99 (ерэн ес) байхаар тогтоосугай.

3.Шинээр батлагдсан ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг баталж, цалингийн эх үүсвэрийг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэхийг “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Наран-Идэрт даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны “Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн схем, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” 528 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА


Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 05 дугаар сарын..... -ны өдрийн  
~~24~~ дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

“ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН БЭЛТГЭЛ, СУРГАЛТЫН ТӨВ”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН БҮТЭЦ,  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 05 дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН БЭЛТГЭЛ, СУРГАЛТЫН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗРЫН АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Орон тоо
1	Захирал	1
2	Ерөнхий менежер	1
	<b>Захиргаа, санхүүгийн алба</b>	<b>16</b>
1	Албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	1
2	Ахлах нягтлан бодогч	1
3	Тооцооны нягтлан бодогч	3
4	Нярав	3
5	Хангамж хариуцсан мэргэжилтэн	2
6	Менежер	3
7	Хуулийн зөвлөх	1
8	Хүний нөөцийн ажилтан	1
9	Архив бичиг хэргийн ажилтан	1
	<b>Маркетингийн алба</b>	<b>4</b>
1	Албаны дарга	1
2	Маркетингийн ажилтан	3
	<b>Сургалтын алба</b>	<b>6</b>
1	Албаны дарга	1
2	Тир зохион байгуулагч	1
3	Дасгалжуулагч	4
	<b>Техникийн алба</b>	<b>28</b>
1	Ерөнхий инженер	1
2	IT инженер	1
3	Дулаан хангамжийн инженер	1
4	Сантехникийн инженер	1
5	ХАБЭА ажилтан	2
6	Заал зохион байгуулагч	2
7	Барилга байгууламж, тоног төхөөрөмж, ашиглалт хариуцсан инженер	1
8	Дуу гэрэлтүүлгийн техникч	2
9	Цахилгааны техникч	5
10	Сантехникч	6
11	Техникийн туслах ажилтан	6
	<b>Нийтлэг үйлчилгээн алба</b>	<b>43</b>
1	Нийтлэг үйлчилгээний ахлах зохион байгуулагч	1
2	Мужаан	2
3	Ахлах тогооч	2
4	Туслах тогооч	4
5	Зөөгч	2
6	Аж ахуй хариуцсан мэргэжилтэн	1
7	Бэлтгэгч, угаагч	2
8	Гадна талбайн үйлчлэгч	3
9	Манаач	5
10	Харуул	6
11	Үйлчлэгч	12
12	Жолооч	3
	<b>НИЙТ ОРОН ТОО</b>	<b>99</b>